

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

**Улаанбаатар хот
2026 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр**

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байна. ТТБЗ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2.-д заасны дагуу Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Монгол Улсын тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүний дагуу ТТБЗ өөрийн дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд *“Дэлхийн болон Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, гадаад, дотоод орчны тодорхой бус байдал нэмэгдэн, иргэдийн орлого, амьжиргаанд үзүүлэх дарамтыг бууруулах, хүнс, эрчим хүчний хангамжийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийг тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээнд чиглүүлэх шаардлага үүсээд байна”* хэмээн тодотгол хийх үндэслэлд дурдсан. Түүнчлэн энэхүү үүсээд байгаа нөхцөл байдлыг сайжруулах үүднээс үндсэн 6 бодлогын арга хэмжээ, хэрэгжүүлэхээр төлөвлөж, төсвийн тодотгол өргөн мэдүүлэх эрх зүйн үндэслэлд Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг дурджээ.

Бидний зүгээс энэ удаагийн төсвийн тодотгол нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан тэвчиж болох зардлуудыг бууруулж, төрийн зардлыг танах, мах, улаанбуудай, хүнсний ногооны нөөц бүрдүүлэх, эрчим хүчний тарифын алдагдал болон станцуудын засвар шинэчлэлд нэмэлт санхүүжилт гаргах, орон нутгийн хуримтлагдсан үлдэгдлийг зорилтот арга хэмжээнд зарцуулах замаар иргэдийн орлого, амьжиргааг үнийн өсөлтөөс хамгаалахад чиглэж буйг ойлгож байгаа ч болзошгүй эрсдэлийг тооцох, хүндрэл бэрхшээл тулгарахад бэлтгэлтэй байх боломжийг ашиглаж чадсангүй гэдгийг дахин сануулж байна. ТТБЗ дүгнэлтдээ төсвийн тодотгол хийх шаардлага, хэрэгжүүлэх бодлого нь өнөөгийн үүсээд байгаа нөхцөл байдалд нийцтэй эсэх, үүнтэй холбоо хийх эрх зүйн болон төсвийн тоон үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь төсвийн тогтолцоо, бодлогод хэрхэн нөлөөлөхийг харгалзан холбогдох судалгаа шинжилгээг хийсэн.

Үүсээд байгаа нөхцөл байдлын эсрэг арга хэмжээ авахдаа төсвийн бодлогын орон зай, нөлөөллийг тодорхойлж, төсвөөр олон жил ужгирсан асуудлыг шийдэх боломжгүй гэдгийг ойлгож, энэ нь эдийн засгийн бүтцийн алдаа болохыг анхаарч, дараа жилийн төсөв, дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай байна. Мөн энэхүү бодлогыг хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх нь эдийн засаг, нийгмийн ямар үр дагаврыг бий болгохыг бодитой тооцож өмнө алдааг давтахгүй байх нь чухал юм. Үүнээс гадна аливаа бодлогын өөрчлөлтийг хийхдээ төсвийн бодлого, төсвийн эрх зүйн орчин, тогтолцоог муутгах асуудлыг цаашид үргэлжлүүлэхгүй байх талаар 2027 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн үеэс эхлэн холбогдох талууд анхаарч ажиллахыг зөвлөлийн зүгээс анхааруулж байна.

Нэг. Төсвийн бодлого, макро эдийн засаг

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн тодотголын төсөлд *“... Иймд 2026 оны төсвийн жилийн үлдсэн хугацаанд төсвийн хөрөнгийг зайлшгүй шаардлагатай, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий арга хэмжээнд төвлөрүүлж, иргэдийн орлого, амьжиргааг хамгаалах, хүнс, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, төсвийн сахилга бат, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсвийн орлого, зарлага, санхүүжилтийн эх үүсвэр болон төсөв зарцуулах эрхийн зохицуулалтад холбогдох*


өөрчлөлт оруулах практик шаардлага бий болж байна” хэмээн төсвийн тодотгол хийх шаардлагыг тодорхойлж энэ хүрээнд доорх өөрчлөлтийг хийхээр тусгасан байна.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн голлох үзүүлэлтүүдийн харьцуулалт, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2026 батлагдсан	2026 тодотгол	Зөрүү	Тайлбар
Нийт орлого	35,253.8	36,172.2	+918.4	Өсөлт нь тэнцвэржүүлсэн орлогод тусахгүй.
Тэнцвэржүүлсэн орлого	31,930.0	31,930.0	0.0	Өөрчлөлтгүй
Нийт зарлага	32,980.0	33,978.0	+998.0	Нэмэгдсэн
Урсгал зардал	24,901.9	26,054.0	+1,152.1	Гол зардлын өсөлт
Хөрөнгийн зардал	8,568.5	8,414.4	-154.1	Буурсан
Цэвэр зээл	-490.4	-490.4	0.0	Өөрчлөлтгүй
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,050.0	-2,048.0	-998.0	Алдагдал нэмэгдсэн
Алдагдал/ДНБ	-1.0%	-2.0%	-1.0%	Хуулийн дээд хязгаарт хүрсэн

1.1. Төсвийн тодотгол хийх шаардлагыг макро эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх явдал хэмээн үзжээ. 2026 оны төсвийн тодотголыг иргэдийн орлого хамгаалах болон стратегийн бүтээгдэхүүн, нефть, эрчим хүчний хангамж найдвартай хангахад чиглүүлж буй нь өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн дүгнэлт хийж, тулгамдсан асуудлыг шийдэх бодлогын сонголт хэмээн үзэж байна. Түүнчлэн гадаад, дотоод нөхцөл байдал, нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсээс шалтгаалж инфляц 13.0 хувь болж өссөн нь иргэдийн амжиргаанд дарамт болж байгааг харгалзан эрэлт, нийлүүлэлтийн талаас хамтад нь шийдвэрлэхийг зорьсон явдал гэж үзлээ. ТТБЗ-ийн зүгээс төсвийн тодотголын төслийг бодлогын хамгийн зөв хувилбар биш гэж үзэж байгаа ч өнөөгийн үүсээд байгаа хүндрэлийг даван гарахыг хичээсэн хувилбар гэж тодотгож байна. Гэхдээ энэ нь голлох бүтээгдэхүүний нийлүүлэлт, үнийг тогтворжуулах бодлого амжилттай хэрэгжиж байж бодитойгоор иргэдийг хамгаалсан бодлого болох боломжтой бөгөөд эсрэг тохиолдолд сөргөөр нөлөөлж болох юм.

Зураг 1. Өрхийн бодит, нэрлэсэн орлогын өсөлт, инфляц




1.2. Төсвийн тодотголоор эрэлт, нийлүүлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч өмнөх алдааг дахин давтах магадлалтай байна. Төсвийн тодотголоор урсгал зардлыг 1,152.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх санал боловсруулсны дийлэнх буюу 697.0 тэрбум төгрөг цалингийн зардалд зарцуулагдахаар байгаа нь одоогийн өндөр инфляцыг улам хөөрөгдөх, нөгөө талаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн стратегийн бүтээгдэхүүний хангамж, эрчим хүчний үнийг тогтвортой барих, нефтийн бүтээгдэхүүний хангамжийг татаас болон татварын хөнгөлөлтөөр шийдвэрлэх арга хэмжээний үр дүн, цаг хугацааны хоцрогдол гарч болзошгүй байдлаас шалтгаалж, сөрөг үр дүнд хүргэх магадлал өндөр байгааг анхаарч бодлогын алдааг давтахгүй байх шаардлагатай байна.

Зураг 2. Цалингийн зардлын өсөлт, инфляц /2000-2026 он/




1.3. Төсвийн бодлогоор дамжуулж эдийн засаг, нийгмийн асуудлыг бүхэлд нь шийдэх боломжгүй гэдгийг ойлгож бодлогын өөрчлөлт хийх шаардлагатай байна. Олон жил үргэлжилсэн бодлогын алдаанаас хамаарсан бүтцийн гажуудлаас үүдэлтэйгээр эдийн засаг эмзэг, эрсдэлтэй болсон. Үүний улмаас үүссэн нөхцөл байдлыг удаа дараа төсвийн тэлэх бодлогоор даван гарах, саармагжуулах оролдлого хийж байсан бөгөөд үр дүнг тооцохгүй цаашид хуучин арга барилаа үргэлжлүүлэх нь эрсдэлтэй тул бодлогын нөлөөллийн судалгааг хийж, бодлогоо эргэж харах нь ирээдүйд тустай төдийгүй нийт улс орон иргэдийн эрх ашигт нийцтэй гэж үзэж байна. Гадаад, дотоод хүчин зүйлсээс хамаарсан эрсдэл тулгарах болгонд Засгийн газрын зүгээс төсвийн зарлага тэлэх, цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх бодлого барьж ирсэн нь нийгэм, эдийн засгийн нөлөөллийн хувьд тухайн үедээ эерэг зүйл мэт харагдавч урт хугацаанд сөрөг нөлөө, түүний төлөөс илүү хүндээр тусах болохыг сануулж байна.

Зураг 3. Төсвийн нийт зардал, цалингийн зардал, НД (тэтгэвэр, тэтгэмж)-ын зардлын өсөлт



1.4. Төсвийн хэмнэлтийг төсвийн бодлогын хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгоход чиглүүлж буй нь сайшаалтай ч бодит хэмнэлт бий болгох, төсвийн бодлогын орон зайг нэмэгдүүлэх хэрэгтэй. Төсвийн тодотголын танилцуулгад дурдсанаар 1.4 их наядын зардлын таналт хийж үүнийг цалин, тэтгэвэр, эрчим хүч, боловсрол, стратегийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнд хуваарилахаар төлөвлөсөн байна. Энэ хэмнэлтийн 52.6 хувь нийслэлийн бондын эх үүсвэр буюу гол хувийн жин эзэлж байна. Мөн зарим хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж, урсгал зардлыг нэмэгдүүлж байгаа нь төсвийн бодлогын орон зайг улам хумих, хөрөнгө оруулалтыг шахах нөхцөл бүрдүүлж байгааг дахин сануулж байна.

Зураг 4. Төсвийн тодотголоор хэмнэж буй зардлын бүтэц (тэрбум төгрөг)



1.5. Төрийн өмчийн шинэчлэлийг бодитой хэрэгжүүлэх нь төсвийн бодлогын нэг чухал хэсэг байх ёстой. Тодотголоор төрийн болон орон нутгийн өмчийн компаниуд, улсын төсөвт үйлдвэрийн газруудын тухайд засаглал, бүтэц санхүүгийн бие даасан байдал, сангийн удирдлага, үнэт цаасны зах зээлд гаргах зэрэг цогц арга хэмжээ авахаар тусгажээ. Эдгээрийг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж чадвал төрийн өмчит компани, улсын төсөвт үйлдвэрийн газруудаас төсөвт ирэх дарамтыг бууруулахаас гадна төсвийн орлогыг нэмэгдүүлэх эх үүсвэр бүрдүүлэх боломжтой. Гэвч шинэчлэлийг хэрхэн хийх үр дүн ямар байхаас шалтгаалах болно гэдгийг хэлэх нь зүйтэй.

1.6. Хувийн хэвшлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх бодлого үгүйлэгдэж байна. Засгийн газраас татварын шинэчлэлийн тухай хууль, “Чөлөөлье” үндэсний санаачилгыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс батлуулан хэрэгжүүлж, үүнд эдийн засгийн чөлөөлөлтийг хамруулж байгаа нь эерэг өөрчлөлт юм. Гэсэн ч төр зардлаа хумьж, төрийн оролцоог бууруулах замаар хувийн хэвшлийг дэмжих арга хэмжээг төсвийн бодлогоор дамжуулан бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай байна. Төсвийн бодлогоор хувийн хэвшлийг дэмжих үйл ажиллагаа тодорхой салбар, стратегийн бүтээгдэхүүний татварын хөнгөлөлт зэрэг явцуу хүрээтэй, харин хамгийн гол нь бүтцийн өөрчлөлтийн дорвитой бодлого үгүйлэгдэж байна. Ерөөс төр хэтэрхий том урсгал зардалтай байгаа нь эдийн засаг дахь бүх нөөцийг (мөнгө, ажиллах хүч) өөртөө татаж, тогтвортой, өндөр цалинтай төрийн алба руу шилжих хөдөлгөөнийг ихэсгэж, эдийн засгийг авч явдаг хувийн хэвшлийнхэнд ажиллах хүчний хомсдол үүсэж, зээлийн олдоц муудан уул уурхайн салбараас хамааралтай “голланд өвчин” гүнзгийрч, бусад баялаг бүтээгч салбарууд нурах зэрэг эрсдэл үүсгэж байгааг үргэлжлүүлж болохгүй гэж үзэж байна.

Хоёр. Төсвийн эрх зүйн орчин, тогтолцооны талаар

2.1. Үндэсний баялгийн сангийн хуулийн өөрчлөлт стратегийн хөрөнгө оруулалтыг бууруулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.10-т төрийн эзэмшилд ногдох ногдол ашгаас Хуримтлалын санд хуульд заасны дагуу хуваарилаад үлдэх хэсгийг “Чингис Хаан үндэсний баялгийн сан” ХХК (хуучнаар Эрдэнэс Монгол нэгдэл)-ийн стратеги төлөвлөгөөнд тусгасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулахаар зохицуулсан. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголтой холбогдуулан уг зохицуулалтыг өөрчилж, Хуримтлалын санд хуваарилсны дараах үлдэх ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлэх болон нэгдлийн стратеги төлөвлөгөөнд туссан үйл ажиллагаанд зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор хуулийн төсөл боловсруулсан байна. Тодотголын хүрээнд ТӨК-иудаас төвлөрүүлэх нийт ногдол ашгийг 1.61 их наяд төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Үүнээс уул уурхайн салбарын ТӨК-иудын ногдол ашгаас 372.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэх бөгөөд үлдэх хэсгээс нэг их наяд төгрөгийг нь улсын төсөвт ногдол ашгийн орлого хэлбэрээр авч, үлдсэн хэсгийг “Чингис Хаан үндэсний баялгийн сан” ХХК-ийн стратеги төлөвлөгөөнд тусгасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулахаар байна. Ингэснээр хөрөнгө оруулалтад зарцуулах эх үүсвэр улсын төсвийн зардлыг санхүүжүүлэх тул зардлын бүтцээс шалтгаалж төсвийн бодлогод сөрөгөөр нөлөөлж болзошгүй байдал үүсэх эрсдэлтэй.

2.2. УИХ-ын тогтоолын өөрчлөлтөөр төсвийн алдагдлыг санхүүжүүлэх орон зай бий болгож байна. Тогтоолын өөрчлөлт нь зарлага бус, санхүүжилтийн эх үүсвэрийг 1,000.0 тэрбум төгрөгөөр тэлж, алдагдлыг санхүүжүүлэхэд чиглэжээ.

Хүснэгт 2. Дагалдах УИХ-ын тогтоолын нөлөө (тэрбум төгрөг)

Дагалдах хууль	Өөрчлөлтийн мөн чанар	2026 нөлөө	Тэмдэглэл / дунд хугацаа
УИХ-ын тогтоолын өөрчлөлт	Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах дээд хэмжээг 561.2 тэрбумаас 1,561.2 тэрбум төгрөгт хүргэх	+1,000.0*	*Төсвийн алдагдлыг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

Гурав. Нийт орлого ба тусламжийн талаар

3.1. Татварын бус орлогын өсөлт төсвийн орлогыг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болж байна. Төсвийн тодотголын төслөөс харахад татварын орлого 1,020.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс буурахаар байгаа бөгөөд үүнийг татварын бус орлогоор нөхөхөөр төлөвлөжээ. Татварын бус орлогыг 1,844.2-2,864.4 тэрбум төгрөгт хүргэж, 1,020.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тусгасан. Энэхүү нэмэгдлийг нийтлэг татварын бус орлого буюу төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ногдол ашгийн орлогын өсөлтөөр бүрдүүлэхээр тооцжээ. Энэ нь эдгээр компаниудын төсөвт төвлөрүүлэх орлогыг тэлэх сайн талтай ч төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа муудах, уул уурхайн салбарын уналт бий болох тохиолдолд төсвийн орлого төлөвлөгөөнөөс дутах, төсвийн алдагдал тэлэх төсвийн шинэ эрсдэлийг бий болгож байна.

3.2. Эрдсийн үнэ, биет хэмжээний өсөлтөөс шалтгаалж баялгийн болон хуримтлалын сангийн орлого нэмэгдэж байна. 2026 оны төсвийн тодотголоор төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 918.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 36,172.2 тэрбум төгрөгт хүргэхээр тооцсон байна. Ингэснээр төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь 34.4-35.3 хувь болж 0.9 нэгж хувиар нэмэгдэхээр байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээг 31,930.0 тэрбум төгрөгт хэвээр буюу батлагдсан дүнгээс өөрчлөлтгүй байхаар тусгажээ.

Нийт орлого ба тусламжийн дүнгийн өсөлт нь Тогтворжуулалтын сан болон Үндэсний баялгийн санд хуримтлуулах орлогын нэмэгдлээр бий болно. Тодруулбал, Тогтворжуулалтын сангийн орлогыг 367.7 тэрбум төгрөгөөс 826.8 тэрбум төгрөгт хүргэж, **459.1 тэрбум төгрөгөөр**, Үндэсний баялгийн сангийн орлогыг 2,956.1 тэрбум төгрөгөөс 3,415.4 тэрбум төгрөгт хүргэж, **459.3 тэрбум төгрөгөөр** тус тус нэмэгдүүлжээ. Иймээс тодотголоор нэмэгдсэн нийт орлогын хэмжээ бүхэлдээ төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлт биш, харин баялгийн орлогыг сангуудад хуримтлуулах хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь байгалийн баялгийн орлогын тодорхой хэсгийг төсвийн урсгал зардалд ашиглахгүйгээр хуримтлуулах, уул уурхайн орлогын хэлбэлзлийн төсөвт үзүүлэх нөлөөг бууруулах эерэг өөрчлөлт гэж үзэх боломжтой.

3.3. Төсвийн орлогын гол бүрэлдэхүүн болох татварын орлогын төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай. Тодотголоор төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан татварын орлого 1,020.2 тэрбум төгрөгөөр буурахаар тооцжээ. Тодруулбал, татварын орлогын талаас илүү хувийг бүрдүүлдэг орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татварын батлагдсан дүнгээс харгалзан 2.7, 3.6 хувиар, гаалийн албан татварыг 17.9 хувиар, онцгой албан татварыг 22.5 хувиар, хөрөнгийн албан татварыг 17.8 хувиар тус тус бууруулсан байна. Ингэснээр татварын орлого 1,020.0 их наяд төгрөгөөр буюу анх төлөвлөсөн хэмжээнээс 3.39 хувиар тасалдаж байгаа нь томоохон дүн юм. 2025 он, 2026 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт өндөр гарч байгаа боловч татварын орлого 2025 онд 2 их наяд, энэ онд 1 их наяд төгрөгөөр тасарч байгаа шалтгааныг судлах, цаашид татварын орлогыг бодитой тооцох шаардлага бий болж байна.

Хүснэгт 3. Татварын орлогын бүтэц (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2025				2026	
	Төсөв	Гүй.	Зөрүү	Бат	Тод	Зөрүү
Татварын орлого	29,241.6	27,212.9	(2,028.7)	30,085.8	29,065.6	(1,020.2)
Орлогын албан татвар	9,370.9	8,560.3	(810.6)	9,248.7	8,999.0	(249.6)
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	5,980.5	5,623.2	(357.4)	6,707.0	6,791.5	84.5
Хөрөнгийн албан татвар	593.8	609.8	15.9	626.9	514.8	(112.1)
Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,646.8	6,207.3	(439.4)	7,408.2	7,142.2	(266.0)
Онцгой албан татвар	1,254.5	949.0	(305.5)	1,331.5	1,031.8	(299.7)
Тусгай зориулалтын орлого	31.5	25.5	(6.0)	33.0	34.9	1.9
Гаалийн албан татвар	2,114.0	1,842.2	(271.8)	2,255.0	1,851.3	(403.7)
Бусад татвар (төлбөр, хураамж)	3,249.5	3,395.6	146.1	2,475.5	2,700.0	224.5

3.4. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, алдагдлыг нөхөх боломжит эх үүсвэрүүдийг нэмэгдүүлсэн нь төсвийн орлогын тасалдал, зардлын тэлэлттэй холбоотой байна. 2026 оны төсвийн тодотголоор төсвийн зарлага 998.0 тэрбум төгрөг, алдагдал 1 их наяд төгрөгөөр нэмэгдэж 2,048.0 тэрбум төгрөг болсон нь ДНБ-ий -2 хувь буюу ДХТХМ-д өөрчлөлт оруулах төсөлдөө тусгасан тусгай шаардлагын хязгаарт тулгаж төлөвлөсөн байна. Татварын орлогын дутагдлаас шалтгаалж зардлын өсөлт алдагдлыг төрийн өмчит компанийн ногдол ашиг, орон нутгийн төсвийн урьд оны ашиглаагүй үлдэгдэл, хөнгөлттэй зээл тусламж, дотоодын үнэт цаас зэрэг эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөж, хууль эрх зүйн орчны өөрчлөлтийг хийхээр тусгажээ. Энэ нь төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжит нэг хувилбар байж болох ч нэг удаагийн шинжтэй, өрийн дарамтыг нэмэгдүүлэх,

төрийн өмчийн компаниудын стратегийн хөрөнгө оруулалтыг бууруулах зэрэг сөрөг нөлөөтэйг анхаарах шаардлагатай.

Дөрөв. Нийт зарлага ба цэвэр зээлийн талаар

4.1. Төсвийн зарлагын гол өөрчлөлт зорилтот бүлгийн орлогыг хамгаалах, эрчим хүчний үнийн дарамтыг бууруулах, хүнсний хангамжийг тогтворжуулахад чиглэж байна. Төсвийн тодотголын танилцуулгад дурдсанаар 1.4 их наядын зардлын таналт хийж үүнийгээ цалин, тэтгэвэр, эрчим хүч, боловсрол, стратегийн нөөц бүрдүүлэх арга хэмжээнүүдэд хуваарилжээ. Дахин хуваарилагдаж байгаа зардлын бүтцээс харахад боловсролын салбарын цалингийн санг нөхөж, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн зардалд 60.0 орчим хувь, суурь тэтгэвэртэй холбоотойгоор 14.0 хувь, стратегийн хүнс, шатахууны нөөцөд 10 хувийг зарцуулахаар төлөвлөсөн (Хүснэгт 5). Гэвч энэ арга хэмжээ ирэх жилүүдийн төсвийн зарлагын ачааллыг улам нэмэгдүүлэх болно. Иймд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа ч дунд урт хугацааны нөлөөллийг сайн тооцож аливаа бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатайг сануулж байна.

Хүснэгт 4. Төсвийн тодотголоор хэрэгжүүлэх арга хэмжээний зарцуулалтын дүн

Арга хэмжээ	Дүн (тэрбум төгрөг)	Эзлэх хувь
Боловсролын салбарын цалин	674.5	46.8%
Ахмадын суурь тэтгэвэр (11-р сараас)	196.3	13.6%
Улаанбуудай, мах, хүнсний ногоо, шатахууны нөөц	150.0	10.4%
Эрчим хүчний үнийн өсөлтөөс хамгаалах дэмжлэг	107.3	7.4%
Эрчим хүчний салбарт засвар, тоног төхөөрөмж	92.7	6.4%
Эрүүл мэндийн салбарын цалин +20% (11-р сараас)	90.0	6.2%
Соёл-спортын салбарын цалин +50%, шинжлэх ухааны салбарын цалин +35% (11-р сараас)	80.1	5.6%
Гэрт ойр сургууль хөтөлбөр	50.0	3.5%
Нийт	1,440.9	100.0%

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

4.2. Төсвийн урсгал зардал, нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэмэгдэж, төрийн оролцоо цаашид ч өсөх хандлагатай болж байна. Төсвийн тодотголоор төсвийн зарлагыг 998 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь 33.2 болж, нэг нэгжээр өссөн нь 2025-2026 онд хэрэгжүүлж ирсэн бодлогын эсрэг байна.


Зураг 5. Нийт зардал, ДНБ-д эзлэх хувь (тэрбум төгрөг)



Төсвийн бодлогын хувьд төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшилд орон зай бий болгох чиг баримжаатай байх нь эдийн засгийн өсөлт, төсвийн орлогын дунд хугацааны өсөлтөд эерэг нөлөөтэй байх учраас Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан бодлогын чиг баримжааг цаашид анхаарч төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.3. Урсгал зардлын өсөлт давамгайлж байгаа нь төсвийн бодлогын орон зайг хумьж байна. 2026 оны төсвийн тодотголоор урсгал зардал 1,152.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэн, 2026 оны ДНБ-д эзлэх урсгал зардлын хэмжээ 25.4 хувьд хүрсэн нь 2026 оны төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд дурдагдсан “Төсвийн урсгал зардлыг 2025 оны түвшинд буюу ДНБ-ий 24 хувьд хязгаарлаж, үр ашигтай, оновчтой байдлаар дахин хуваарилах” бодлоготой зөрчилдөж байна.

Зураг 6. Урсгал зардал, өсөлтийн хувь (2016-2026 он, тэрбум төгрөг)



Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны урсгал зардлын 56.6 хувийг тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө болон боловсрол, эрүүл мэндийн салбарын цалин хөлс, 15.8 хувийг бусад салбарын цалин, нэмэгдэл, урамшуулал, 5.3 хувийг зээлийн хүүгийн төлбөр эзэлж байна. Энэ бүтэц төсвийн зардлын уян хатан байдлыг хязгаарлаж, ирээдүйд орлого буурсан тохиолдолд богино хугацаанд танах боломжтой зардлын эзлэх хувийг багасгаж эрсдэлийг нэмэгдүүлнэ. Иймд цаашид цалин тэтгэвэр нэмэх иргэдийн орлогыг хамгаалах гэх мэт бодлого хэрэгжүүлэхдээ эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын нөлөөллөөс гадна ирээдүйд төсөвт ирэх дарамт, түүний эерэг, сөрөг нөлөөллийг сайтар тооцож байх шаардлага улам нэмэгдэж байна.

4.4. Тодотголын хүрээнд шинээр нэмэгдэж буй зардлуудын дийлэнх нь хуульчлагдсан байна. 2026 оны төсвийн тодотголд суурь тэтгэвэр олгох хугацааг наашлуулах, төрийн үйлчилгээний бүх салбарын цалинг 2025 оны суурь түвшнээс 50 хувиар нэмэгдүүлэх, Боловсролын салбарын багш, ажилтны цалингийн 50 хувийн нэмэгдлийн бүтэн жилийн дутуу санхүүжилтийг олгох зэрэг зардлуудыг тусгасан нь нийт дүнгээр 1,040.9 тэрбум төгрөг болж байна. Энэхүү нэмэгдлийн 366.4 тэрбум төгрөг нь шинэ бодлогын шинжтэй нэмэгдэл, 674.5 тэрбум төгрөг нь өмнөх шийдвэрийн санхүүжилтийн нөхөлт байна. 366.4 тэрбум төгрөгийн 196.3 нь суурь тэтгэврийн хугацааг наашлуулахтай холбоотой зардал юм. Иймд цаашид цалин, тэтгэвэр, нийгмийн халамж болон бусад чиглэлээр хууль батлахдаа эдийн засаг, төсөвт нөлөөлөх нөлөөлөл, санхүүгийн ачааллыг нарийвчлан тооцож байх шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 5. Төсвийн тодотголд тодорхой дүнтэй тусгасан зардлууд, тэрбум төгрөг.

№	Хуулийн өөрчлөлттэй уялдах арга хэмжээ	Зориулалт	2026 онд нэмэгдэх	Зардлын шинж
1	Суурь тэтгэврийг 2026 оны 11 дүгээр сараас олгох	435.0 мянган ахмад настанд сард 100-300.0 мянган төгрөг олгох	196.3	Шинээр бий болох зардал
2	Төрийн үйлчилгээний бүх салбарын цалинг 2025 оны суурь түвшнээс 50 хувьд хүргэж жигдрүүлэх	Эрүүл мэнд +20 нэгж хувь, шинжлэх ухаан +35 нэгж хувь, бусад төрийн үйлчилгээ +50 нэгж хувь	170.1	Шинээр бий болох зардал
3	Боловсролын салбарын 50 хувийн цалингийн нэмэгдлийн бүтэн жилийн дутуу санхүүжилт	93.5 мянган багш, ажилтны цалин	674.5	Өмнө гарсан шийдвэрийн санхүүжилтийн нөхөлт
	Нийт		1,040.9	

Эх сурвалж: Сангийн яамны 2026 оны төсвийн тодотголын төслийн товч танилцуулга

4.5. Төсвийн зарлага, санхүүжилтийн зохистой бүтэц алдагдаж байна. Төсвийн тодотголоор төсвийн зарлагыг 998 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, 1.4 их наяд төгрөгийн зардлыг танах байдлаар зардлын бүтцэд өөрчлөлт оруулсны улмаас урсгал зардал 1,152.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Хөрөнгийн зардлаас хэмнэлт хийж, урсгал зардлыг санхүүжүүлэхэд хөнгөлттэй зээл, татварын бус орлого зэрэг эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөжээ. Ийнхүү байнгын шинж чанартай урсгал зардлыг хөрөнгийн зардлын хэмнэлт, тогтвортой бус нэг удаагийн шинжтэй эх үүсвэрээр санхүүжүүлэх нь цаашид төсвийн төлөвлөлт, хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэхийг тооцоолох, эрсдэлийг үнэлэх шаардлагатай.


Тав. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар

5.1. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэж, урсгал болон бусад зардалд шилжүүлэх хандлага хэвшил болж байна. Сүүлийн жилүүдэд хэмнэлтийн тухай хуулиар 05 дугаар сарын 31-ний дотор гэрээ байгуулаагүй улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээг зогсоож, санхүүжилтийг нь буцаан татах, үүнийгээ хэмнэлтэд тооцох хандлага хэвшил болж байна. 2026 оны төсвийн тодотголоор 249.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг “хэмнэж” тодотголын хүрээнд хэрэгжүүлэх зардлуудыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилтэд сөрөг нөлөөтэйг анхаарч хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд илүү анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Зургаа. Засгийн газрын өр, алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, эрсдэл

6.1. Засгийн газрын өрийн хэмжээ нэмэгдэж, бүтэц өөрчлөгдөж байна. Төсвийн тодотголоор Засгийн газрын гадаад үнэт цаас 758.0 тэрбум төгрөгөөр буурсан бол дотоод үнэт цаас 1,084.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Түүнчлэн Засгийн газрын гадаад зээл 1,190.9 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 7. Засгийн газрын өр, тэрбум төгрөг, өрийн ДНБ-д эзлэх хувь



6.2. Өрийн өсөлт хурдтай нэмэгдэхээр байгаа тул үүсэх эрсдэлийг нарийвчлан тооцох шаардлагатай. Төсвийн тодотголд “Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар нэрлэсэн дүнгээр 35.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьтай тэнцэж байсан бол 2026 оны эхний хагас жилийн байдлаар 36.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.5 хувьтай тэнцэж байна”, “Шинээр авах төсвийн дэмжлэгийн зээл, дотоод үнэт цаас болон өрийн баталгааны дүнг оруулан тооцоход Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2026 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ-ий 44.5 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.” гэсэн нь өрийн хэмжээнд гарч байгаа өөрчлөлтийг илэрхийлж байна.

6.3. Төсвийн алдагдал, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл нь өр нэмэгдэх шалтгаан болж байна. Тодотголын нөлөөгөөр төсвийн алдагдал 1 их наяд төгрөгөөр нэмэгдэж 2,048 тэрбум төгрөг болсон нь ДНБ-ий -2 хувь буюу тусгай шаардлагын хязгаарт тулсан байна. Энэхүү алдагдлыг Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжүүлэхээр байна. Мөн төсвийн тодотголын баримтад төсвийн алдагдлын хэмжээг дурдаж “Иймд Засгийн газраас төрийн сангийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх, дотоодын зах зээлийн хөгжлийг дэмжих, улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2026 онд Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргах дээд хэмжээг 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж 1,561.2 тэрбум төгрөг болгохоор Монгол Улсын 2026 оны тодотголын төсөлд тусгалаа” гэсэн төсвийн орлогын тасалдлаас шалтгаалж, үнэт цаас гаргах нөхцөл бүрдсэнийг харуулж байна. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” УИХ-ын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 102 дугаар тогтоолд Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах хязгаарыг 561.2 тэрбумаас 1,561.2 тэрбум төгрөг болгож, нэг их наяд төгрөгөөр нэмэгдүүлэх өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэ нь төсвийн орлого жигд бус, улирлын хамааралтай үед (жишээ нь, оны эхний хагаст) дотоод бондоор эх үүсвэр бүрдүүлж, бүтээн байгуулалтын төслүүдийн санхүүжилтийг гацаахгүй үргэлжлүүлэх боломж олгох, Засгийн газар гадаад зах зээлээс ам.доллараар зээл авахын оронд дотоодоос төгрөгөөр санхүүжилт босгосноор ханшийн савлагаанаас үүдэх өрийн дарамтаас сэргийлэх ач холбогдолтой байж болох ч нөгөө талаас арилжааны банкууд хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд зээл олгохоос илүүтэйгээр эрсдэлгүй, найдвартай Засгийн газрын бондыг худалдаж авахыг урьтал болгодгоос үүдэн хувийн хэвшилд очих зээлийн олдоц багасаж, хүү өсөх, түүнчлэн нэг их наяд төгрөгийн нэмэлт өр үүсэж байгаа тул дараагийн жилүүдийн төсвөөс эргэн төлөлт болон хүүгийн зардалд их хэмжээний мөнгө хуваарилах шаардлага тулгарна.

Хүснэгт 6. Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Төрөл	Тоо хэмжээ	Төсөвт тусгасан хэлбэр	Тайлбар
Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх гадаадын хөнгөлөлттэй зээл	2,048.0 тэрбум төгрөг	Санхүүжилтийн эх үүсвэр	2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлыг бүрэн санхүүжүүлнэ.
АХБ-ны төсвийн дэмжлэгийн зээл	200.0 сая ам.доллар	Бэлтгэж буй санхүүжилт	Төсөв, төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулах зорилготой.
Нөхцөлт зээлийн шугам	250.0 сая ам.доллар хүртэл	Бэлтгэж буй эх үүсвэр	Байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал зэрэг үед ашиглах санхүүжилтийн эх үүсвэр.
Гадаад тусламжийн төсөл	50.0 тэрбум төгрөгөөр бууруулсан	Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт	Хэрэгжилт, гэрээ, ажлын төлөвлөгөө, бодит хэрэгцээнд үндэслэн бууруулсан.

Долоо. Төсвийн тусгай шаардлага хангасан эсэх талаар


7.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 133.7 ам.доллар байхаар өмнө нь төсөөлж батлагдаж байсан үнээр тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.

7.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд 2.0 хувийн, 2027 онд 1.5 хувийн, 2028 онд 1.0 хувийн алдагдалтай байхаар тусгасан нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх хуулийн хязгаарт нийцэхээр байна. (Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах төсөлд 2024 оны 08 дугаар сараас хойш мөрдөгдөж байсан “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх” гэсэн заалтыг хүчингүй болгохоор тусгасан.)

7.3. Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан байдаг. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдлийг 2026 он болон 2027-2029 онд ДНБ-ий 50 хувьд байхаар тооцсон нь хуульд заасан өрийн дээд хязгаараас 10 нэгж хувиар доогуур бөгөөд уг төсөл нь хуулийн шаардлагыг хангаж байна.

7.4. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2026 онд 8.4 хувиар, 2027 онд 7.4 хувиар, 2028 онд 5.8 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт болон өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджаас аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан зохицуулалттай нийцэж байна.

Зураг 8. 2026 оны төсвийн зарлага, уул уурхайн бус салбарын өмнөх 12 жилийн дундаж өсөлтийн харьцуулалт



7.5. Урсгал зардал. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төсөлд нэгдсэн төсвийн урсгал зардлыг 26,054.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг дүн нь тухайн жилийн ДНБ-ий 25.4 хувьтай тэнцэж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн урсгал зарлага тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагаас 4.6 нэгж хувиар доогуур байна. Иймд 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгасан урсгал зардлын хэмжээ нь уг төсвийн тусгай шаардлагыг хангаж байна гэж дүгнэж байна.

Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тодотголын төсөлд дүн шинжилгээ хийсний үр дүнд дараах дүгнэлтүүдийг гаргалаа.

1. Төсвийн бодлогод дорвитой өөрчлөлт хийх шаардлага нэгэнт бий болжээ. ТТБЗ-ийн зүгээс төсвийн тодотголын шаардлага, зорилгыг өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд иргэдийн амжиргааг хамгаалах, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ гэж үзэж байгаа ч хэрэгжүүлэх арга замын хувьд туйлын зөв сонголт гэж үзэхгүй байна. Харин зорилго нь зөв ч хэрэгжүүлэх аргын хувьд анхаарах хэрэгтэй сонголт гэж хэлж болох бөгөөд цаашид энэ хэвээр үргэлжлүүлэх нь эрсдэлтэй болохыг анхаарах нь зүйтэй байна. Үүний тулд өмнө нь төсвөөр эдийн засаг, иргэдийг хамгаалах бодлого ямар үр нөлөө, үр дагавартай байсныг нягтлах хэрэгтэй.

Цаашид төрийн хэмнэлтийн асуудлыг илүү бодитой хэрэгжүүлэх, төрийн бүтцийг боловсронгуй болгох, төрийн оролцоог бууруулах замаар зардлын бодитой хэмнэлтийг бий болгох арга замыг эрэлхийлэх шаардлагатай. Өнөөдөр тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорихын зэрэгцээ төсвийн бодлогыг сайжруулах, бүтцийн гажуудлыг засахад чиглэсэн бодлогын эхлэлийг тавих цаг нэгэнт болсон бөгөөд цаашид өнөөгийн хэлбэрээр үргэлжлүүлэх нь эдийн засагт сөрөг нөлөөлөх, төсвийн ачаалал даахгүй эрсдэл үүсэх нөхцлийг бий болгох болно.

2. Төсвөөр эдийн засаг, нийгмийн тулгамдсан бүх асуудлыг шийдэх гэж оролдох, төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын алдаа хэвээр үргэлжилсээр байна. Гадаад дотоод орчны нөлөөлөлд өртөмтгий эмзэг эдийн засгийн бүтэцтэй болсон нь олон жилийн улбаатай нь үнэн боловч үүнийг дан ганц төсвийн бодлогоор шийдвэрлэх боломжгүй гэдгийг ойлгож өөрчлөх нь зүйтэй. Харин хувийн хэвшил суурьтай эдийн засаг бий болгох,

хувийн хэвшлийг бодитой дэмжих, эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах нь эдийн засаг нийгмийн суурь асуудлыг шийдвэрлэх гарц гэж үзэж байна.

4. Эрх зүйн орчны өөрчлөлт төсвийн бодлого, зарлагын өсөлтөд хүчтэй нөлөөлж байна. Нэгдүгээрт, дийлэнхдээ УИХ-аас батлагдсан хууль, тогтоомжийн хүрээнд төсвийн зарлагыг тэлэх нөхцөл бий болж байгаа бол, хоёрдугаарт, төсвийн зохицуулалттай холбоотой хуулиудыг өөрчилж төсвийн зарлага тэлэх, орлогыг нэмэгдүүлэх, санхүүжүүлэх орон зайг бий болгох практик хэрэгжиж ирсэн. Эдгээрийг дараагийн төсвийн төлөвлөлтөд анхаарч төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд бодлого, эрх зүйн тогтвортой байдлыг бий болгох шаардлагатай.

5. Төсвийн орлогын эмзэг байдал, тасалдах эрсдэл улам нэмэгдэж байна. Эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр байгаа ч татварын орлого буурч буйг анхаарах шаардлагатай. Татварын орлогын бууралтыг татварын бус орлогоор нөхөх хувилбар нь төсвийн орлого бүрдүүлэлтийг улам эмзэг болгох эрсдэлтэй байна. Учир нь, төрийн болон орон нутгийн өмчит ААН-үүдийн ногдол ашиг нь голчлон уул уурхайн салбараас хамаарах тул орлого бүрдүүлэхэд учрах эрсдэл нэмэгдэх нь тодорхой.

6. Төсвийн зарлага, урсгал зардал нэмэгдэж, төсвийн бодлогын орон зай хумигдаж байна. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ нэмэгдэж, ялангуяа урсгал зардлын эзлэх хувь өсөх нь төсвийн бодлогын орон зайг багасгах, эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй бөгөөд цаашид энэ байдлыг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулахгүй бол төрийн оролцоо улам нэмэгдэх хандлага бий болж байна.

7. Засгийн газрын өрийн бүтэц, хэмжээ, ашиглалтын үр нөлөөг тодорхойлох бодит шаардлага бий болсон байна. Хэдийгээр ДНБ-д эзлэх өрийн хэмжээ хуулийн хязгаарт багтаж байгаа боловч өр хурдтай нэмэгдэх магадлалтай нь төсвийн тодотголын төслөөс харагдаж байна. Мөн өрөөр алдагдал, урсгал зардлыг санхүүжүүлэх арга барил нь буруу жишиг хэмээн үзэж байгаагаа дурдах нь зүйтэй. Иймд одоо хүртэл бий болсон өрийн шалтгаан, зарцуулалт үр нөлөөг судалж тодорхойлох, цаашид өрийг бий болгохдоо бүтэц, зориулалт, үр нөлөөг тооцож байх шаардлагатай байна.

Зөвлөмж

1. Төсвийн тэлэлт нь түр зуурын шинжтэй эерэг нөлөө үзүүлэх боломжтой ч ирээдүйд гарах эрсдэл бодит үр дүнг харгалзаж дараагийн төсвийн төслийг бэлтгэх, хэлэлцэх батлахад анхаарах;
2. Цаашид мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлж эдийн засгийн бүтцийн гажуудлыг засах, төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлийг дэмжихэд чиглүүлэх, өмнө хэрэгжүүлсэн болох цаашид хэрэгжүүлэх төсвийн бодлогын эдийн засаг, нийгмийн үр нөлөөг тогтмол, бодитой үнэлэх арга барил нэвтрүүлэх;
3. Төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
4. Төсвийн зарлагад нөлөөлөх эрх зүйн орчны өөрчлөлтийг хийхдээ дунд хугацааны төсөвт нөлөө, төсвийн ачааллыг тооцдог байх;
5. Цалин тэтгэвэр нэмэх асуудлыг эдийн засгийн бодит өсөлт, бүтээмж, салбарын үр дүнтэй уялдуулах;
6. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор төсвийн бодлогыг өөрчлөх, хувийн хэвшлийг дэмжиж татварын суурийг нэмэгдүүлэх шаардлага бий болсныг анхаарч энэ чиглэлд бодлогын бодит өөрчлөлт хийх;

7. Төсвийн тодотголын хүрээнд эх үүсвэрийг нэмэгдүүлж буй хувилбаруудтай холбоотой асуудлыг зохицуулж байгаа Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар батлагдсан холбогдох журмуудыг дахин сайтар нягтлан үзэж илүү боловсронгуй болгох шаардлагатай.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ